

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Ай санагтун, санагтун

Далын ахлагч Чи Хонг (Сэм) Вонг

Азийн бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх



Далын ахлагч
Чи Хонг (Сэм) Вонг

Ахлагч Жэффри Р.Холланд 1995 Оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр ариун ёслолын үүсэл, зорилгын талаар нэгэн гайхалтай үг хэлсэн билээ. “Сүүлчийн бөгөөд онцгойлон бэлтгэсэн Дээгүүр өнгөрөх баярын үдшийн зоог өндөрлөх үед Есүс талх аваад адисалсны дараа, хуваан Төлөөлөгчдөдөө өгөөд “Май, ид” (Матай 26:26). “Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд” (Лук 22:19) гэж айлдав. Үүний адилаар, тэр мөн аягатай дарс авч, “Энэ нь та нарын төлөө асгагдах Миний цусаар тогтоох шинэ гэрээ юм” “энэ бол нүглүүдийн уучлалын тулд . . . урсах . . . Миний цус” “Намайг дурсаж үүнийг үйлд” хэмээн хэлсэн (Лук 22:20, Матай 26:28, Лук 22:19).

“Гетсеманий болон Голготын өмнөх орой, дээд давхрын өрөөнд болсон тэрхүү үйл явдлаас хойш, амлаалтын хүүхдүүд Христийн золиослолыг энэхүү илүү шинэ бөгөөд эрхэм, илүү ариун бөгөөд хувийн арга замаар дурсан санах гэрээнд байсаар байгаа билээ.”¹ Ахлагч Холланд цааш нь “Хэрвээ дурсан санах нь бидний үндсэн үүрэг юм бол, эдгээр тодорхой хийгээд эрхэм бэлгэдлүүдийг бидэнд өгөгдөх үед бидний дурсамжинд юу орж ирэх бол?”² гэж асуужээ.

Бид юуг санах ёстой вэ?
Хүүхдүүдээ хамгийн чухал зүйлсийг сануулах зорилгоор эхчүүд “санагтун, санагтун” гэх мэт байнга давтагддаг үгсийг хэрэглэдэг. Тэнгэрлэг Эцэг ч үүнтэй адил зүйл хийдэг байж магадгүй гэж бид боддог. Мормоны Номд “санагтун, санагтун” гэдэг холбоо үгийг таван удаа хэрэглэсэн байдаг. Бүгдээрээ хамтдаа Мормоны Номын тэдгээр жишээг судлан, Тэнгэрлэг Эцэг маань бидний санах ёстой зүйлсийн талаар ямар нэгэн санааг үлдээсэн эсэхийг үзэцгээе.

Лемен үндэстэн Самуел— “Өөрсдийнхөө төлөө үйлд”

Лемен үндэстэн Самуел ёс бус нифайчуудад хандан хангалттай их сэрэмжлүүлж мөн бошиглосон. Тэр хэрэв нифайчууд ёсон бус амьдралаар амьдарсаар байвал тэдэнд устгал ирэх болно гэдгийг сэрэмжлүүлж мөн Христийн төрөлт, амьдрал, үхэл болон Амилаалтын талаар бошиглосон байдаг. Тэд өөрсдийнхөө төлөө үйлдэх эрх чөлөөтэй ч ийнхүү үйлдэхдээ зөвхөн Есүс Христийн Цагаатгалаар болон өөрсдийнхөө үйлдлээр дамжуулан аврагдана гэдгээ мартаж өсгүй хэмээн тэр хэлжээ. “Мөн эдүгээ санагтун, санагтун, ах дүүс минь, мөхөх

хэн боловч, өөртөө мөхөх буюу; мөн алдсыг үйлдэх хэн боловч, үүнийг өөртөө үйлдэх буюу; учир нь болгоогтун, та нар чөлөөтэй; өөрсдийнхөө төлөө үйлдэх нь та нарт зөвшөөрөгдсөн билээ; учир нь болгоогтун, Бурхан та нарт мэдлэг өгч мөн тэрээр та нарыг чөлөөтэй болгосон буюу”³.

Тэрээр биднийг өөрсдийнхөө төлөө үйлдэж, ийн үйлдэхдээ өөрсдийн хийвэл зохих сайн зүйлсийг санаж мөн хийж байхыг хүсдэг.

Залуу Алма—“Зарлигууд нь чанд болой”

Залуу Алма эсэргүүцэл, наманчлалын цаг үеийг туулсан ба хожим нь Бурханы бошиглогч болсон юм. Тэрээр хөвгүүдээ, ялангуяа Хиламанд өгсөн сургаалуудаараа дамжуулан агуу зөвлөгөөг бидэнд өгсөн билээ. “Ай Хиламан хүү минь, Бурханы зарлигууд ямар чанд болохыг санагтун, санагтун. Мөн тэрээр хэлсэн нь: Хэрэв та нар миний зарлигуудыг дагавал та нар уг нутаг дэгжих болно—харин хэрэв та нар түүний зарлигуудыг дагахгүй аваас та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно”.⁴

Эдгээр нь санаа зовсон эцгийн хатуу үгс байв. Тэрээр хөвгүүдээ зарлигуудыг дагах, дагахгүй байхын

үр дагавруудыг чанд байдлаар хуваалцдаг байсан. Яагаад ийм хатуу гэж? Аливаа зүйлс яагаад илүү амар хялбар байж болохгүй гэж? Нифай аливаа зүйлсийг дэндүү амар хялбар байлгахыг хүсдэг хүмүүст “. . . Сионд сэрэмжгүй байгч түүнд халаг!”⁵ хэмээн ухаалгаар сэрэмжлүүлжээ. Хэрвээ бид дуулгавартай байдалдаа дэндүү хайнга хандах юм бол биднийг уурлуулахаар өдөөн хатгаж, төөрөлдүүлж, тайвшруулан, зусардахад мөн биднийг хүлж, тамруу доош удирдахад Сатанд илүү амархан байх болно. Та нар “Сионд сэрэмжгүй байх”⁶ -ыг өөрсдөдөө бүү зөвшөөр. Хөгжин дэгжихийг хүсвэл “зарлигуудыг дагахаа санагтун, санагтун.”

Хаан Бенжамин—“Төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвч”

Бүхий л судар дээрх хамгийн хүчирхэг сургаалуудын нэгийг хаан Бенжамин айлдсан байдаг. Есүс Христийн үнэнч шавийн амьдралаар амьдрахаас гадна, хаан Бенжамин “. . . зарлигуудыг дагадаг тэд . . . мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс . . . тэд тэнгэрт хүлээн авагдах болно”⁷ хэмээх үнэн гэж мэддэг зүйлсээ хүмүүсийг ойлгоосой гэж хүсдэг байсан. Тэрээр “Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэнийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан юм”⁸ хэмээн урамшуулахдаа зэмлэж байгаагаар онцолсон билээ. Хаан Бенжамин Их Эзэн Бурхан энэ амлалтыг өгсөн бөгөөд эцсээ хүртэл итгэлтэйгээр

тэвчих эсэх нь биднээс хамаарна гэдгийг сануулсан.

Нифай, Лихай хоёр—“Гэтэлгэгчийн хадан дээр”

Сайн мэдээг түгээхэд бүхнээ зориулсан хоёр үйлчлэгч болох Нифай, Лихай нар олон сорилт бэрхшээлийг туулсан юм. Тэд зовж зүдэрч байхдаа эцэг Хиламаныхаа үгсийг санадаг байсан. “. . . Санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; . . . бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой”⁹. Энэ нь бидэнд сэтгэлээр унагасан зүйлс, сорилт эсвэл зовлон бэрхшээл тохиолдохгүй гэсэн үг биш бөгөөд харин бид бат бөх суурийг тавьснаараа тэдгээрийг тэсч гарахад хэрэгтэй хүч чадлыг олох болно. Бидний суурь хаана байна вэ? Энэ нь юун дээр босгогдсон бэ? Энэ нь хэр бат бөх байна вэ? Хэрэв та байшингаа элсэн дээр барьсан хэвээр байгаа бол байршлыг нь өөрчил!

Хиламан—“Зөвхөн Есүс Христийн цагаатгагч цусаар дамжин”

Хаан Бенжамин бас “Гэвч Их Эзэн Бурхан түүний хүмүүс хөшүүн хүзүүтэй хүмүүс байсныг харсан, мөн тэрээр тэдний дээр нэгэн хуулийг, бүр Мосегийн хуулийг тогтоосон билээ. Мөн олон тэмдэг, мөн гайхамшгууд, мөн бэлэгдлүүд, мөн дүрслэлүүдийг тэрээр тэдэнд

үзүүлсэн, өөрийн ирэлтийн талаар буюу; мөн түүнчлэн ариун бошиглогчид түүний ирэлтийн талаар тэдэнд ярьсан бөлгөө; тийм хэдий ч тэд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн Мосегийн хууль түүний цусны цагаатгалаар бус аваас огтхон ч тус болохгүйг ойлгосонгүй”¹⁰ гэж заасан.

Мормоны Номон дээр хожим нь Хиламан хөвгүүддээ зөвлөгөө өгөхдөө хаан Бенжамин үгсийг “Ай санагтун, санагтун . . . хүмүүн аврагдаж чадах өөр бусад зам ч, бас арга ч үгүй, зөвхөн ирэх, Есүс Христийн цагаатгагч цусаар дамжин гэдгийг санагтун”¹¹ хэмээн бататгажээ. Тиймээс бат бөх хөдөлшгүй суурийг тавих хамгийн чухал хэсэг нь Есүс Христийн Цагаатгал юм.

Бид хэрхэн санаж чадах вэ?

Дагах зарчмууд нь энгийн хэдий ч чанд байдаг. Бид сонгох эрхээ ухаалгаар ашиглаж, өөрсдийн амьдралыг Аврагчийнхаа хадан дээр барьж босгон, эцсээ хүртэл итгэлтэй байх хэрэгтэй. Бид Есүс Христийн цагаатгагч цусаар дамжуулан мөнхийн сүр жавхланд Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин нэгдэх боломжтой болох юм. Ариун ёслолын цуглаан бол “Сүмийн цуглаануудаас хамгийн ариун нандин цуглаан юм.”¹² Бид Аврагчийн алдар суугийн төлөө бүхнээ зориулахад бэлэн байгаагаар харуулаад зогсохгүй бас өөрсдийнхөө өдөр бүр хийдэг, хэлдэг зүйлсээр Түүний тэнгэрлэг байдлын

үнэнийг гэрчлэн эдгээр бэлгэдлийг хүртэх ёстой. ■

Ахлагч Чи Хонг (Сэм) Вонг

ЭШЛЭЛҮҮД

1. Жэффри Р.Холланд, "This Do in Remembrance of Me," 1995 оны 10-р сарын Ерөнхий Чуулган, <http://www.lds.org/general-conference/1995/10/this-do-in-remembrance-of-me>
2. 1-ийг үзнэ үү.
3. Хиламан 14:30.

4. Алма 37:13.
5. 2 Нифай 28:24-ийг үзнэ үү.
6. 5-ийг үзнэ үү.
7. Мозая 2:41-ийг үзнэ үү.
8. 7-г үзнэ үү; хаалтан доторх нэмэлттэй.
9. Хиламан 5:12-ыг үзнэ үү.
10. Мозая 3:14-15.
11. Хиламан 5:9.
12. Жозеф Фийлдинг Смит, Conference Report, 1929 оны 10-р сар, 60-61-ийг үзнэ үү; түүнчлэн *Doctrines of Salvation*, ed. Bruce R. McConkie, 3 боть (1954-56), 2:340-341; Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Жозеф Фийлдинг Смит (2013), 95-ыг үзнэ үү.

ОРОН НУТАГТ БОЛЖ БУЙ ҮЙЛ ЯВДЛУУД

Ховд салбарын чуулган боллоо

Ховд салбарын чуулган 2015 оны 9 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд амжилттай болж өнгөрлөө. УБ Баруун Гадасны ерөнхийлөгч О.Одгэрэл, түүний нэгдүгээр зөвлөх Т.Баатарчулуун болон Гадасны туслах бүлгийн удирдагчид Ховд аймагт очиж тус чуулганыг зохион байгуулсан юм.

Эхний өдрийн чуулган Бугатын үзүүр хэмээх газар болсон бөгөөд Ховд салбарын нийт гишүүд, удирдагчид оролцсон. Тэд Гадасны удирдагчдын заасан сүнслэг өртөөнүүдээр аялж, олон зүйл сурсан. Зарим гишүүнтэй уулзаж, сурсан зүйлийнх нь тухай сонирхлоо.



Ховд салбарын гишүүд Бугатын үзүүр хэмээх газарт чуулганы үеэр

С.Цацрал

“Бурханы өмнө хүлээх үүрэг”

өртөө

Би энэ өртөөнөөс ганцаараа л сүмдээ яваад байх биш, бусдад ч бас сүнслэг байдлын хувьд өсөж, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах хэрэгтэй гэдгийг сурлаа. Өөрт оногдсон үүргийг сайн биелүүлэх нь өсч хөгжихөд тусалдаг. Би маргааш болох ариун ёслолд гэр бүлийн гишүүдээ заавал авчирна.

Э.Таван-Эрдэнэ

“Ариун өдөр” өртөө

Би урьд нь ариун өдрийг хэзээ ч ариунаар нь сахиж байгаагүй гэдгээ мэдэж авлаа. Энэ өдөр нь онцгой өдөр учир залбиралтайгаар өнгөрүүлэх ёстой бөгөөд хувцаслалт ч бас бусад өдрийнхөөс өөр байх ёстойг сурсан. Хэрвээ бид залбирвал Тэнгэрлэг Эцэг энэ өдрийг ариунаар хадгалах арга замаар хангаж өгнө. Бүтэн сайн өдрийг ариунаар сахиж маш их хүсэл төрж байна.

Б.Амарзаяа /сонирхогч/

Би эдгээр өртөөнөөс амьдралд хэрэгтэй олон зүйл сурлаа. Наманчлалын өртөө их таалагдсан. Хийсэн бүх алдаагаа залруулж, нүглээсээ цэвэршиж болно гэж бодохоор их сайхан санагдаж байна. Би сүмийг олон жил сонирхож байгаа. Гэхдээ одоо гишүүн болж, илүү тууштай явахаар шийдсэн. Бас семинарт явна.

П. Буяннэмэх

“Номлол” өртөө

Номлол бол санваарын үүрэг. Тиймээс Бурханы өмнө хүлээсэн энэ эрхэм үүргээ заавал биелүүлэх ёстойг ойлгосон. Номлолд гарахыг их хүсэж байна. Гэхдээ сайн бэлдэх хэрэгтэй юм байна.

Г. Батболд

“Хангамжийн төв” өртөө

Хангамжийн төв миний бодсоноос хамаагүй ойр байдаг юм байна. Каталогоос нь хараад хүссэн зүйлээ захиалж авч болдгийг сурлаа.

Б. Болортуяа

“Бие даах чадварыг хөгжүүлэх нь” өртөө

Бие даах чадвар гэдэг нь хүн хэн нэгнээс хараат бус байх явдал юм. Би ирээдүйд бие даах чадвартай байхын тулд одооноос төлөвлөгөө гаргаж, зорилго тавих хэрэгтэй гэдгээ ойлгосон. Өнөө орой гэртээ очоод тэмдэглэл хөтөлж эхэлнэ. Бас ойрын хугацаанд ямар мэргэжлээр, ямар сургуульд суралцах талаараа шийдвэр гаргана гэж бодож байна.

С. Марал-Эрдэнэ

“Хувийн хөгжил дэвшил” өртөө

Хувийн хөгжил дэвшил хөтөлбөрийг хөтөлснөөр хувиараа өсөж дэвших боломжтой бөгөөд залбирал амжилттай хөтөлөхөд тусалдаг гэдгийг сурлаа. Би энэхүү хөтөлбөрийг хэд хэд эхэлсэн боловч дандаа л шантраад орхидог байсан. Харин

одоо үргэлжлүүлж хөтлөөд заавал дуусгана гэсэн зорилго тавьсан.

Чуулганд ирсэн хүн бүр дор бүрнээ хувийн илчлэлт авч, сүнсээр суралцаж чадсан юм. Сүнслэг төөнүүдээр аялсны дараа бүгд хөгжилтэй тоглоом тоглож, амтат зууш идэцгээв. Дараа нь өсвөр үеийнхэн сүмийн байранд очиж, Гадасны залуу эрэгтэй, эмэгтэйчүүдийн удирдагчдаар бугуйвч урлахыг заалгав. Хүн бүр өөрийн гэсэн бүтээлтэй болж, түүгээрээ гангарсаар буцаагаалаа. Ийнхүү эхний өдрийн чуулган амжилттай болж өндөрлөв.

Чуулганы хоёр дахь өдөр бол ариун өдөр. Ариун ёслолын цуглаан хүндэтгэл бишрэл ба Ариун сүнсээр дүүрэн байлаа. Гишүүд ерөнхийлөгч Томас С.Монсоноос эхлээд Гадасны болон Ховд салбарт

үйлчилдэг бүхий л албан тушаалтнуудыг дэмжин батлав. Энэ үед Ховд салбарын Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөл солигдож, шинэ ерөнхийлөгчөөр Д.Дагвадорж эгч дуудагдсан. Гадасны туслах бүлгийн удирдагчид хөгжмийн онцгой номер үзүүлсэн. Ховд салбарын ариун ёслол ба хичээл нийлээд хоёр цаг байдаг байсан бөгөөд энэхүү чуулганаар гурван цаг буюу туслах бүлгүүдийн анги нэмэгдэн орох болоо. Ариун ёслолын дараа Гадасны удирдлагууд тус тусын бүлгийн удирдагчдад сургалт өгсөн юм. Дашрамд дурдахад урьд нь Ховд салбар Монгол Улаанбаатар номлолын харьяанд байсан бөгөөд өнгөрсөн гуравдугаар сард Тэргүүн Зөвлөлийн зөвшөөрлөөр Улаанбаатар Баруун Гадасны нэгж болсон билээ. ■

Сэлбэ тойргийнхон ариун сүм рүү хамтдаа аяллаа

Монголд анх удаа тойргийн ариун сүмийн аялал зохион байгуулагдлаа. Сэлбэ тойргийн удирдлагууд тойргоороо ариун сүм явах зорилго тавин олон сар бэлдсэний эцэст ийнхүү 11 хүний бүрэлдэхүүнтэй баг аравдугаар сарын 11-21-ний өдрүүдэд Хонконгийн ариун сүмд орж, олон хүний авралын

ёслолуудыг гүйцэтгэжээ. Аяллын багт Н.Сүнжидмаа, В.Уламбаяр, М.Мөнгөнтуяа, Э.Удвал, Б.Төгсжаргал, Н.Хишигдэмбэрэл, Н.Бадмаанямбуу, Н.Ганболд, С.Сүхзориг, Э.Оюунбаяр, С.Ариунхишиг нар явсан байна. Тэд Хонконгоор аялахын зэрэгцээ ариун сүмд орж, авралын ёслолуудаа хүлээн авснаар итгэл гэрчлэлээ



Ариун сүмийн аялалд оролцсон Сэлбэ тойргийн гишүүд



Н.Хишигдэмбэрэл: “Анх удаа ариун сүмд орлоо. Хувийн хишгээ хүртэж, гармент өмсөх болсондоо маш их баярласан ба энэхүү өмсгөл маань намайг хамгаалж байгааг мэдэрсэн. Мөн нас барсан хайрт аав, ээжийнхээ авралын ёслолуудыг хийлгэх үедээ тэднийхээ их баярлаж байгааг мэдэрч байлаа. Их Эзэний өргөөнд Ариун Сүнснийг илүү хүчтэй мэдэрдэг болохыг анзаарсан.”

бэхжүүлсэн тухай өөрсдийн гэрчлэлийг хуваалцсан юм.

Н.Бадмаанямбуу: “Би жил гаруйн өмнө Сүмийн гишүүн болсон. Ариун сүмд орж, 23 жилийн өмнө нас эцэслэсэн ханьтайгаа мөнхийн холболт хийлгэсэн. Хайрт ханиа зүүдэлж, дахин уулзана гэсэн баттай мэдрэмж хүлээн авсан. Нас барсан хамаатан садныхаа 9 хүний авралын ёслолуудыг хийлгэсэн бөгөөд тэдний ихэд баярлаж байгааг мэдэрсэн. Ариун сүмд л бид ийм гайхалтай зүйлсийг мэдэрч болдог юм байна гэж би ойлгосон.”

Н.Сүнжидмаа: “Энэ удаагийн аялаар би ариун сүмд хоёр дахь удаагаа орсон. 100 гаруй нас барагсдын нэр цуглуулж, авч явсан. Олон хүний авралын ёслол

хийлгээд үнэхээр сайхан байлаа. Гэхдээ заримынх нь ёслолыг хийлгэж амжаагүй. Ариун сүмд орох үедээ Алма 34:32-т хэлсэнчлэн энэ дэлхийн амьдрал бол үнэхээр Бурхантай уулзахаар бэлтгэх үе гэдгийг мөн нас барагсдыг аврах нь бидний бэлтгэлийн бас нэгэн чухал хэсэг гэдгийг мэдэж авлаа.”

Б.Уламбаяр: “Анх удаа ариун сүмд орж үзлээ. Нөхөр маань 6 жилийн өмнө нас барсан бөгөөд түүнийхээ авралын ёслолуудыг хийлгэж, мөнхөд холбуулсан. Энэхүү ёслолуудыг гүйцэлдүүлж байхдаа түүнтэйгээ дахин уулзана гэдгийг мэдрээд их баярласан даа. 2017 онд гэр бүлээрээ дахин ариун сүм явах зорилго тавьсан. Монголд хурдан ариун сүм баригдаасай л гэж хүсэж, залбирч байна.”

Б.Төгсжаргал: “Би анх 1996 онд Сүмийн гишүүн болсон. Ариун сүм рүү явахыг үргэлж хүсдэг байсан ч тодорхой зорилго тавьж, дорвитой хичээж байсангүй. Харин өнгөрсөн гуравдугаар сараас эхлэн манай тойргийн зөвлөл тойргийн ариун сүмийн аялал зохион байгуулах гэж байгаа тухай мэдээд бэлдэж эхэлсэн. Бурхан хүн бүрд ариун сүмд орох цагийг нь бэлтгэсэн байдаг гэдгийг мэдэж авсан. Анх ариун сүмд орохдоо бага зэрэг эмээж байсан ч ёслолуудаа хүлээн авснаар Ариун Сүнсээр дүүрч, тайтгарсан. Хайрт ээжийнхээ ёслолуудыг гүйцэтгэх явцдаа бид Бурхан Эцэгтээ эргэн очиж, Түүнтэй мөнхөд хамт амьдрах болно гэдгийг илүү хүчтэй мэдэрсэн.” ■

Хөдөлмөрийн үнэ цэнэ

Сүхбаатар салбар У.Саранцэцэг

Манай салбарын Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгч Бямбаа эгч надаас Буяндэлгэр эгчийнд айлчилж, ярилцахыг хүссэн учир би тэднийд зочилсон юм. Буяндэлгэр эгч 60 орчим настай, намхан нуруутай, аливаа зүйлд хариуцлагатай ханддаг, сайн мэдээний дагуу хичээнгүй амьдардаг, эгэл даруухан агаад хөдөлмөрч нэгэн билээ. Ярилцах үедээ би түүнээс олон зүйл сурч бас ихэд бахархав. Түүний итгэл, ажил хөдөлмөрийн тухай гайхалтай түүхийг “Лиахона” сэтгүүлийн уншигч та бүхэндээ уламжилъя.



Ж.Буяндэлгэр эгч ногооны талбай дээрээ

Тэрбээр “Намайг Ж.Буяндэлгэр гэдэг. Манайх гэр бүлээрээ Сүмийн гишүүд. Бид олон жил хашаандаа хүнсний болон нарийн ногоо тарьж, үр шимийг нь хүртсээр ирсэн. Мөнхийн хань маань дэргэд байх тэр жилүүдэд би ногоо тариалах ажилд нь багахан хувь нэмэр оруудаг байлаа. Харин ханиа тэнгэрт хальснаас хойш бие даан ажиллах болсон. “Алтны дэргэдэх гууль шарладаг” гэдэг дээ. Энэ жил сонгино, жууцай, бууцай, юуцай, чинцай, яншуй зэрэг 10 гаруй төрлийн ногоо тарьсан. Ногоо тарьж ургуулах явцад Бурханы бүтээл хэчнээн гайхалтайг бишрэн, урамтай хөдөлмөрлөдөг. “Чи духныхаа

хөлсийг дуслуулан байж хоолоо олж ид”, “Юу тарина түүнийгээ хураана” гэх судрын үгсийг үргэлж санадаг бөгөөд энэ үгс надад эрч хүч өгдөг. Тарьсан бүх үр тус тусын өнгө төрхөө олж, төрөл бүрийн ногоо болон ургахад газрын шим, гарын бүтээлээ харан сэтгэл баясдаг юм. Хураасан ногоогоо орсон гарсан олон түмэнтэйгээ хувааж идээд, сэтгэл хангалуун сайхан байдаг. Ногоогоо хүнсэндээ хэрэглэн, илүү гарсныг нь зарж борлуулдаг. Үүний зэрэгцээ цэцэг тарих хоббитой болсон. Өглөө бүр өнгө засан ургаж байгаа цэцэгсээ яг л амьд бодгаль шиг хайрлан арчилдаг. Тарих цэцгийнхээ тоог нэмсээр энэ жил 136 цэцэг тарьсан.



Намар сургууль цэцэрлэг эхлэх үеэр хүүхдүүдэд цэцгээ зарж, хөдөлмөрийн минь хөлс мөнгөөр үнэлэгддэг. Энэ жил тарьсан цэцэгс маань хагас сая гаруй төгрөг болсон бөгөөд Бурхандаа аравны нэгээ баяртайгаар өргөсөн. “Гар хөдөлбөл ам хөдөлнө” гэдэг үнэн үг шүү. “. . . энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр” (Алма 34:32) хэмээх судрын шүлгэнд би дуртай” гээд яриагаа дуусгасан юм. Буяндэлгэр эгч ногоо, цэцэг тарихын зэрэгцээ шүрээр бүтээл урлан, нэхмэл нэхдэг гарын дүйтэй хүн билээ. Мөн чөлөөт цагаараа шүлэг зохиож, цаг үргэлж хөдөлмөрлөж байдаг уйгагүй хүн. Гэрийнх нь ханаар түүний урласан бүтээлүүд өлгөөтэй байдаг бөгөөд хүмүүст бас бэлэглэдэг. Гэрт нь очсон хүн бүрд тарьсан ногоогоороо сайхан хоол хийж өгч, охин Энхтуяагийнхаа хийсэн нарийн боовоор дайлна. Бурхан бүх хүнд ийм гайхалтай чадварыг өгдөг бөгөөд түүнийг уйгагүй хөгжүүлж, жаргалтай амьдарч байгаа гишүүдийн нэг нь Буяндэлгэр эгч юм. ■

ГЭГЭЭНТНҮҮДИЙН АМЖИЛТЫН ТҮҮХ

А.Баярсайхан чадварлаг тоглолтуудаараа гайхшируулж байна



А.Баярсайхан довтолж байна



Саяхан Бригам Янгийн их сургуулийн эмэгтэйчүүдийн гар бөмбөгийн “Seasiders” баг Калифорнийн Баптист их сургуулийн шигшээ багтай нөхөрсөг тоглолт хийжээ.

Тоглолтын эхний хоёр үед Баптист баг 25-22, 25-14 оноогоор тоглолтыг хошуучилж эхэлжээ. Тиймээс “Seasiders”-г хожих боломж тун бага байлаа. Тоглолт энэ байдлаараа дуусах байх гэж ихэнх хүн үзэж байсан ч гуравдугаар үеэс эхлэн байдал өөрчлөгдсөн юм. “Seasiders” тоглолтын хувь заяаг эргүүлж, сүүлийн гурван үеийн тоглолтыг 25-23, 25-9, 15-13 гэсэн оноотойгоор, алгасалгүй хожсоор өрсөлдөгчөө буулган авч чаджээ. Бригам Янгийн их сургуулийн ахлах дасгалжуулагч Мона Ах-Хое “Би охидоороо бахархаж байна. Сүүлчийн гурван үед тэд үнэхээр гайхалтай тоглосон. Ялангуяа А.Баярсайхан, Малари нар чадварлаг тоглолтоороо биднийг алмайруулсан” гэжээ. А.Баярсайханы довтолгоо багтаа хожлын оноонуудыг авчирсан бөгөөд тэрээр багийнхаа шилдэг тоглогчдын нэг болж чаджээ. ■

ИНСТИТУТ, СЕМИНАР ГИШҮҮДИЙН АМЬДРАЛД

Семинарын ангийн ТӨГСӨГЧ

Э. Цолмонгийн гэрчлэл

Би сүмд өнгөрүүлсэн есөн жилээ семинаргүйгээр төсөөлж чадахгүй. Семинарт суралцсан дөрвөн жилийн хутагаа надад Бурханы сургаалын үнэ цэнийг ойлгуулж, сургаалд хандах хандлагыг минь

өөрчилсөн. Нэгэн үе би тойргийнхоо семинарын ангийн цорын ганц суралцагч байсан. Ганцхан миний төлөө санваартан ах нар өглөө бүр машинаараа хүргэн өгч, сүмийн байрыг онгойлгон, семинарын багш



Э.Цолмон


маань гайхалтай хичээл бэлдэн заадаг байсан. Мөн Халамжийн нийгэмлэгийн эгч нар багш бид хоёрт өглөөний унд бэлтгэж авчирдаг байлаа. Яагаад семинарын ганц суралцагчийн төлөө эдгээр ах эгч ийм их золиослол, үйлчлэл хийж байгаа юм бол гэж бодох үедээ би судрын үнэ цэн, цаашлаад сургаалын үнэ цэн миний төсөөлж чадахаас хэд дахин илүү гэдгийг ойлгох шиг болсон. Семинарын анги гайхалтай бөгөөд Христийн зан чанаруудыг хөгжүүлж, сургаалд гүн хөрвөгдөх боломжийг бидэнд олгодог. Мөн би семинарт суухдаа хэзээ ч ганцаараа байдаггүйгээ мэдсэн. Бас олон сайн найзтай болж, хамтдаа судраас судлах нь миний хувьд том адислал байсан. Би семинарын хөтөлбөрийг дуусгаж чадсандаа баяртай байгаа бөгөөд чин сэтгэлээ зориулан үйлчлэдэг бүх ах, эгчдээ талархал илэрхийлж байна. Бурханы сургаал агуу бөгөөд бидний зүрх сэтгэлийг өөрчлөх хүчтэйг би семинарт суралцах үедээ мэдэрсэн. Мөн Аврагчийн хийсэн Цагаатгал бидний амьдрал дахь бүх зүйлд нөлөөлдөг гэдгийг Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен. ■

ИНСТИТУТИЙН АНГИЙН ТӨГСӨГЧ

Э.Тулгын гэрчлэл

Институт миний амьдралыг дараах таван арга замаар адисалсан. Тухайлбал:

1. Номлолын минь хамгийн бат бөх суурь институт байсан юм. Номлол хийхэд шаардлагатай байсан бүхий л мэдлэг, гэрчлэлийг би институтээс олж авсан. Би институтэд суулгүйгээр номлолд гарсан бол номлолоо амжилттай дуусгаж чадахгүй байсан гэж боддог.
2. Би зөв зохистой, адил жишигтэй, хөгжилтэй найзуудаа институтээс олсон. Хамтдаа хийдэг байсан институтын үйл ажиллагаанууд биднийг илүү дотно болгосон бөгөөд тэд бол миний мөнхийн найзууд гэдэгт би итгэдэг.
3. Институтэд суух үедээ, хийсэн алдаа дутагдаа сайтар ойлгож, илүү цэвэр ариун байх хүсэлтэй болдог. Бүрэн дүүрэн наманчилж, сургаалд илүү гүн хөрвөгдөхөд Бурханы үг л бидэнд тусалдаг.
4. Тухайн үед манай институтийн ангийн дарга байсан охин одоо



Э.Тулга, гэргий
Б.Жанлавцогзолын хамт

миний эхнэр болсон юм. Үзэсгэлэнтэй эхнэрээ би институтээс л олсон.

5. Би институтэд явснаараа ариун сүмд ороход өөрийгөө бэлтгэж чадсан. Эхнэр бид хоёр Хонконгийн ариун сүмд мөнхөд гэрлэх боломжоор адислагдсан юм.

Институт бидний амьдралыг адисалдаг гэдгийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен. ■